

# ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2024 оны 05 сарын 24

№ ТУЗ 24/1

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

### *Гүйцэтгэх захирал шинээр томилох тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8-р зүйл, Глобал лайф технологи ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2024 оны 05-р сарын 24-ний өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөл”-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Гүйцэтгэх захирал He Jingwen-ийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, Shih Pei Chih-ийг Гүйцэтгэх захирлаар томилсугай.
2. Гүйцэтгэх удирдлагыг шинээр томилсон өөрчлөлтийг улсын бүртгэлийн газар холбогдох бүртгэлийг хийлгэхийг Б.Ганчимэг /ОЮ91042108/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



*У.Б. МОНТГОМЕР* U. B. MONTGOMER/

# ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2024 оны 05 сарын 24

№ ТУЗ 24/2

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал  
зарлан хуралдуулах тухай*

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 61.1.5, 67.1, 71.3, 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн зар хүргэх журам”, Глобал лайф технологи ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2024 оны 5-р сарын 24-ний өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөл”-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 07 сарын 08-ны өдрийн Даваа гарагийн 14:00 цагт “Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, 12-р хороолол, Залуучуудын өргөн чөлөө, North center, 207 тоот” хаягт зарлан хуралдуулсугай.
2. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 06 сарын 17-ны өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг “хавсралт №1”-ээр баталсугай.
4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2024 оны 05 сарын 27-ны өдөр болон, давтан 15 хоногийн дараа буюу 06 сарын 12-ны өдрөөр тогтоож, зарын агуулгыг “хавсралт №3”-аар баталсугай.
5. Хувьцаа эзэмшигчдэд ээлжит бус хурлын материалыг 2024 оны 05 сарын 24-ны өдөр үнэт цаасны компанид цахим шуудан болон бичгээр илгээх ба хувьцаа эзэмшигчид компанийн байранд 05 сарын 24-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд ирж танилцаж болохыг түгээсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг “хавсралт №2”-аар баталсугай.
7. Бичгээр санал авах хуудсыг хүлээж авах сүүлийн хугацааг 2024 оны 07 сарын 05-ны өдрийн 17 цагаас өмнө компанийн байранд ирүүлсэн байхаар тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд санал авах хуудсыг “хавсралт №4”-өөр баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах комиссын даргаар гүйцэтгэх захирал Shih Pei Chih, гишүүнээр ТУЗ-ын нарийн бичгийн дарга Я.Отгонжаргал нарыг томилсугай.
10. Хурлын тооллогын комиссын даргаар Б.Ганчимэг, гишүүнээр Н.Алтанзул нарыг томилсугай.


ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/YEN MONTGOMER/

# ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2024 оны 05 сарын 24-ны өдрийн  
ТУЗ-24/2 тоот тогтоолын хавсралт 1




## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. 2023 оны санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. 2023 оны ногдол ашгийн талаарх шийдвэрийг танилцуулах
3. 2024 оны ТУЗ-ийн төсвийг батлах
4. Компанийн үндсэн хөрөнгийг нэмэгдүүлж, үндсэн хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийх саналыг танилцуулах
5. ТУЗ-ийн 9 гишүүний бүрэн эрхийн хугацааг сунгах



# ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2024 оны 05 сарын 24-ны өдрийн  
ТУЗ-24/2 тоот тогтоолын хавсралт 2



## ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН БЭЛТГЭЛИЙН ЯВЦАД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НАРТ ТАНИЛЦУУЛАХ БИЧИГ БАРИМТ

1. Хурал хуралдуулах тухай тогтоол
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас
4. 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, аудитын тайлан
5. 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт
6. Хурлаас гарах шийдвэрийн төсөл
7. КТХ 65.6-д заасан бусад баримт бичгүүд

# ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2024 оны 05 сарын 24-ны өдрийн  
ТУЗ-24/2 тоот тогтоолын хавсралт 3



## ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2024 оны 07 сарын 08-ны өдрийн Даваа гарагийн 14:00 цагт “Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, 12-р хороолол, Залуучуудын өргөн чөлөө, North center, 207 тоот” хаягт болно.

Хэлэлцэх асуудал:

1. 2023 оны санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. 2023 оны ногдол ашгийн талаарх шийдвэрийг танилцуулах
3. 2024 оны ТУЗ-ийн төсвийг батлах
4. Компанийн үндсэн хөрөнгийг нэмэгдүүлж, үндсэн хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийх саналыг танилцуулах
5. ТУЗ-ийн 9 гишүүний бүрэн эрхийн хугацааг сунгах эсэхийг хэлэлцэн батлах

Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2024 оны 06 сарын 17-ны өдрөөр тасалбар болно.

Хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд саналаа 2024 оны 07 сарын 05-ны өдрийн 17:00 цагаас өмнө компанийн байранд ирүүлсэн байна.

Хувьцаа эзэмшигчид санал авах хуудас болон хурлын материалтай танилцахдаа 2024 оны 05 сарын 24-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд компанийн байранд ирнэ үү.

Жич: Хуралд оролцохдоо өөрсдийн иргэний үнэмлэх, гадаад паспортыг авч ирнэ үү.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

УТАС: 95757676, 95290020



# ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

Глобал лайф технологи ХК-ийн  
2024 оны 05-р сарын 24-ны өдрийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн  
ТУЗ 24/2 тоот тогтоолын Хавсралт 4



Annex 4 to Global life technology JSC  
Board of Directors meeting  
Resolution No. TV3 24/2  
dated 24 May 2024

## ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС 1 (BALLOT 1 FOR AGM)

Хувьцаа эзэмшигчдийн овог (Surname) .....нэр (Name).....  
Регистрийн дугаар (Registration number or Personal ID).....  
Эзэмшиж буй хувьцааны төрөл (Type of share/s):  
Эзэмшиж буй хувьцааны тоо .....  
Бүртгэсэн ҮЦК-ийн нэр: .....  
Брокерийн овог, нэр: .....

Хуралдсан огноо (Date of the Board meeting): 2024 оны 7 сарын 08-ны өдөр 14:00 цаг (05<sup>th</sup> of July, 2024  
14:00 PM)

Хуралдсан хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, 12-р хороолол, Залуучуудын  
өргөн чөлөө, North center, 207 тоот ( #207, North center, Youth Avenue, 12<sup>th</sup> khoroolol, 1<sup>st</sup> khoroo, Bayanzurkh  
district, Ulaanbaatar city, Mongolia on 08 July 2024 at 14:00)

№	Хэлэлцэн батлах асуудал Matter of decision	Зөвшөөрсөн / Agree	Татгалзсан/ Disagree	Түдгэлсэн/ Abstain from voting	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал (If disagree, please note your opinion)
1	2023 оны санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах (Affirming board's conclusion on financial and operational report)				
2	2024 оны ТУЗ-ийн зардлын төсвийг батлах (Affirming budget of the BOD for 2022)				
3	ТУЗ-ийн 9 гишүүний бүрэн эрхийн хугацааг сунгахыг батлах (To approve term extentsion for nine board members)				

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү. (Please mark ✓)

Хувьцаа эзэмшигч (Signature here).....

Саналын хуудсыг хүлээн авсан.....

# ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2024 оны 05 сарын 24

№ ТУЗ 24/3

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

ХУРЛЫН ТОГТООЛ

*Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах тухай*

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг энэхүү тогтоолын хавсралтын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



BYN MONTGOMER/

# ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

---

2024 оны 05 сарын 24-ны өдрийн  
ТУЗ-24/3 тоот тогтоолын хавсралт



## 2024 ОНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

- Цалин 3,600,000 төгрөг
- Хурал зохион байгуулах зардал 500,000 төгрөг



# ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2024 оны 05 сарын 24

№ ТУЗ 24/4

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт болон тайлангийн тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 96 дугаар зүйлийн 96.5 дугаар зүйлийн дагуу Глобал лайф технологи ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2024 оны 05-р сарын 24-ний өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөл”-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнг хүлээн зөвшөөрсүгэй.
2. Компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг хүлээн зөвшөөрсүгэй.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан, зохих шийдвэрийг гаргуулахыг Гүйцэтгэх захирал Shih Pei Chih -д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



SHIH PEI CHIH / MONTGOMER/

# ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2024 оны 05 сарын 24

№ ТУЗ 24/5

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

### ХУРЛЫН ТОГТООЛ

*Ногдол ашиг хуваарилахгүй байх*

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.6, Глобал лайф технологи ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2024 оны 05-р сарын 24-ний өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөл”-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тус компанийн 2023 оны үйл ажиллагааны үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байх үндэслэлийн талаарх Гүйцэтгэх захирлын танилцуулгыг сонсож, тус компанийн 2023 оны ашгийн үр дүнгээр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байх талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлэхээр шийдвэрлэсүгэй.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан, зохих шийдвэрийг гаргуулахыг Гүйцэтгэх захирал Shih Pei Chih -д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



*Shih Pei Chih*  
SHIH PEI CHIH / YUEN MONTGOMER/